

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	2
2	Аудитын тайлан .....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал 8	
2.9.	ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ ....	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.11	Шилэн дансны мэдээлэл .....	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал.....	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	13
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	14
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	16
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	18
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	19
4.6	Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	21
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	22

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ МУЗЕЙН  
ДАРГА Д.СҮХБААТАР ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.02.05 № 06/302  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монголын үндэсний музейн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Монголын үндэсний музейн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монголын үндэсний музейн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2 АУДИТЫН ТАЙЛАН**

### **2.1 ОРШИЛ**

Монголын үндэсний музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус музейн дарга Д.Сүхбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монголын үндэсний музейн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монголын үндэсний музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 25-наас 2019 оны 2 дугаар сарын 16-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Пийк Ом Аудит ХХК-ийн аудитор А.Мөнхцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

Монголын Үндэсний Музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Пийк Ом Аудит ХХК-д 2019 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 14 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Монголын үндэсний музейн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

#### *Эрхэм зорилго:*

Монголын үндэсний музей нь музейн үйлчилгээг олон улсын жишигт хүргэж өргөжүүлэх, сан хөмрөг, хадгалалт хамгаалалт, үйлчилгээний орчинг сайжруулах, судалгааны болоод дотоод, гадаадын соёлын өвийн байгууллагатай хамтын ажиллагаагаа эрчимжүүлэх, бүс нутагт өөрийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, Монголын түүх соёлын өвийн хадгалж, хамгаалах, цуглуулах, судлан сурталчлах, Монгол орны нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах, үзэгчид, залуу үеийнхэнд эх оронч үзлийг төлөвшүүлэх, өв соёл, түүхэн уламжлалаа хойч үедээ өвлүүлэн үлдээх, дэлхийн ард түмнүүдэд эх орныхоо түүх, соёлыг сурталчлан таниулах зорилготой байна.

#### *Үйл ажиллагааны чиглэл:*

Монголын үндэсний музейн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Соёлын өвийг хадгалж, хамгаалан хойч үедээ уламжлуулах;
- Иргэдийн оюуны тодорхой эрэлт хэрэгцээг хангах;

Монголын үндэсний музейн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Монголын үндэсний музейн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Монголын үндэсний музейн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Монголын үндэсний музейн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Монголын үндэсний музейн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянаад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Монголын үндэсний музейн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын 1.0 хувиар сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тус байгууллагын орлогын 59.1 хувийг улсын төсвийн санхүүжилт эзэлдэг, үр дүнгийн тайланд тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зардал бодитоор илэрхийлэгддэг зэрэгтэй холбоотой юм.

Монголын үндэсний музейн 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,386,291.5 мянган төгрөг бөгөөд түүний 1.0 хувь болох 13,862.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.0 хувиар тооцсон нь эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал  
/мянган төгрөгөөр/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	7,647.7	
	Дүн	3	7,647.7	

### 2.8.1 ЗӨВЛӨМЖ ӨГӨХӨӨС БУСАД ХЭЛБЭРЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДАЛ

Аудитын явцад залруулсан алдаа зөрчлийн дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Тайлант онд худалдан авсан 2,252.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг зардалд тайлагнасан байгаа нь нь УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 13 (б)-д “Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм” гэж тодорхойлсон заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: санхүүгийн тайланд залруулга хийлгэв.

2. Бүртгэлгүй байсан 48,392.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлж бүртгэхдээ засгийн газрын оруулсан капитал дансаар бүртгэсэн байгаа нь Сангийн сайдын 2018 оны 207 тоот тушаалын 5.3-д заасан заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: санхүүгийн тайланд залруулга хийлгэв.

3. Мөнгөн гүйлгээний тайланд нийгмийн даатгалын сангаас олгох жирэмсэн, амаржсан, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж болох 3,156.1 мянган төгрөгийн тэтгэмжийг цалингийн зардлаар бүртгэсэн нь Монгол Улсын Сангийн сайдын 2008 оны 352 тоот тушаалаар шинэчлэгдэн баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: санхүүгийн тайланд залруулга хийлгэв.

### 2.9. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц бусад чухал асуудлыг доор тэмдэглэв Үүнд:

- 2017 онд боловсруулсан НББ-ийн бодлогын баримт бичигт үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцох Засгийн газрын 2005 оны 233 тоот хүчингүй болсон тушаалыг мөрдөхөөр заасан байна;
- Сан хөмрөгийн эрхлэгчээр ажиллаж байсан ажилтан түүхийн үнэт үзмэр болох эд өлгийн зүйлийг хууль бусаар завшин үрэгдүүлж 44,905.5 мянган төгрөгийн хохирол учруулснаас Монгол Улсын Дээд Шүүхийн 2010 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 283 дугаар тогтоолын дагуу 35,028.6 мянган төгрөгийн өрийг барагдуулсан байна;
- Тухайн музей нь гадаадын жуулчид ирэх магадлал, эх орны өв сан түүхийг монголчуудад үнэ төлбөргүй сурталчлах, сургуулийн сурагчдад үзүүлэх тухай Боловсрол соёл шинжлэх ухаан, спортын сайдын холбогдох тушаал шийдвэр болон өмнөх оны биелэлт зэргээ харгалзан өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогыг жил бүр нэмэгдүүлэн төлөвлөж иржээ. Сүүлийн 3 жилийн байдлаар төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн байна.

- 2019 оноос өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө тэглэгдсэн буюу музей төсвөөс бүрэн санхүүжихээр зохицуулагдсан хэдий ч өөрийн үйл ажиллагааны орлогыг зарцуулах журам батлагдаагүй байна.

Иймд цаашид эдгээр асуудлын талаар холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

## 2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Монголын үндэсний музей чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 802,292.3 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 801,854.9 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь урсгал зардлын хэмнэлт 437.4 мянган төгрөгийн дутуу зарцуулалтаас шалтгаалжээ.

## 2.11 Шилэн дансны мэдээлэл

Монголын үндэсний музей нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Монголын үндэсний музей нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “*shilendans.gov.mn*” цахим хуудсаар “*Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам*”-ын дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр ил тод мэдээлж ажилласан байна. Үүнд:

- Батлагдсан төсөв /бүтэн жилээр/
- Дараа жилийн төсвийн төсөл /бүтэн жилээр/
- Санхүүгийн тайлан /хагас, бүтэн жилээр/
- Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /бүтэн жилээр/
- Аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан /бүтэн жилээр/
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт /бүтэн жил, хагас жил, улирал, сар бүр/
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ /тухай бүр/
- Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлт /тухай бүр/

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100.0 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Монголын үндэсний музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Монголын үндэсний музейн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Монголын үндэсний музейн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### ***Авлагатай холбоотой асуудал***

##### **1.1. Илрүүлэлт:**

Төсвийг зүй зохистой удирдаагүйгээс 1,023.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*" гэж заасантай нийцээгүй байна.

##### **1.2. Эрсдэл:**

Энэ нь "Эрх ба үүрэг" батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна найдваргүй авлага үүсэх, хууль тогтоомж зөрчигдөх эрсдэл үүсгэж байна.

##### **1.3. Өгсөн зөвлөмж:**

Харьяа дүүргийн татварын хэлтэст 2019 оны ХХОАТ-ын ногдлоос суутган тооцох хүсэлт өгч шийдвэрлүүлэх.

##### **1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

##### **2.1. Илрүүлэлт:**

УБЦТС ХК-д 2017 оны жилийн эцсийн тайлангаар 1,068.7 мянган төгрөг илүү шилжүүлсэн боловч авлагаар бүртгээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д *"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д заасан *"дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"* гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

#### 2.2. Эрсдэл:

Энэ нь "Эрх ба үүрэг" батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна найдваргүй авлага үүсэх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэл үүсгэж байна.

#### 2.3. Өгсөн зөвлөмж:

Харилцагч байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж бүртгэлд үнэн зөв тусгаж байх.

#### 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

### **Бараа материалтай холбоотой асуудал**

#### 3.1. Илрүүлэлт:

Өмнөх жилүүдэд зарцуулсан боловч бараа материалын тайланд үлдэгдлээр илэрхийлэгдэж байсан 5,556.0 мянган төгрөгийн машины сэлбэг хэрэгслийг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын 2018 оны 11 дүгээр сарын 21-ний №15/8 тоот тэмдэглэлийг үндэслэн акталсан байна.

#### 3.2. Эрсдэл:

Энэ нь "Үнэн зөв байдал" батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна хөрөнгө дутагдах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэл үүсгэж байна.

#### 3.3. Өгсөн зөвлөмж:

Бараа материалын зарлагыг тайлант онд нь шаардах хуудсаар зарлага болгож байх.

#### 3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

##### 4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>186,778,662.95</u></b>	<b><u>214,469,444.28</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	10,721,417.20	13,545,700.03
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	10,721,417.20	13,545,700.03
3351	Байгууллагаас авах авлага	10,721,417.20	13,545,700.03
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	176,057,245.75	200,923,744.25
35300	Бэлэн бүтээгдэхүүн	31,515,111.00	42,695,802.50
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	144,542,134.75	158,227,941.75
35410	Бичиг хэргийн материал	2,587,708.00	5,049,000.00
35420	Аж ахуйн материал	4,125,580.00	3,854,960.00
35470	Бусад хангамжийн материал	137,828,846.75	149,323,981.75
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>5,480,939,793.12</u></b>	<b><u>8,661,746,552.03</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	5,480,939,793.12	8,661,746,552.03
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	5,480,475,126.31	8,552,649,085.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,200,545,273.00	3,744,762,600.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-481,931,172.52	00.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	93,915,703.75	93,915,703.75
39204	Хуримтлагдсан элэгдэл	-85,156,072.52	-87,709,282.88
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	964,830,950.90	1,005,321,455.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	-377,764,271.07	-451,079,458.71
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	103,222,687.00	156,622,367.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-50,553,725.79	-55,493,453.42
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	4,086,561,017.00	4,119,264,417.00
39217	Ном	26,804,736.56	27,044,736.56
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	464,666.81	109,097,466.83
39301	Програм хангамж	2,445,000.00	2,445,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,980,333.19	-2,144,333.17
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	108,796,800.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>5,667,718,456.07</u></b>	<b><u>8,876,215,996.31</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>5,667,718,456.07</u></b>	<b><u>8,876,215,996.31</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	5,667,718,456.07	8,876,215,996.31
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,206,524,764.40	1,315,321,564.40
51101	Өмч: - төрийн	1,206,524,764.40	1,315,321,564.40
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,922,482,602.50	2,024,418,355.34
51210	Өмнөх үеийн үр дүн	1,922,482,602.50	1,922,482,602.50
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	101,935,752.84
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,538,711,089.17	5,536,476,076.57
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>5,667,718,456.07</u></b>	<b><u>8,876,215,996.31</u></b>

## 4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,367,868,632.75</b>	<b>1,488,227,296.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>275,360,289.75</b>	<b>392,126,365.78</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	275,360,289.75	392,126,365.78
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	275,360,289.75	392,126,365.78
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	222,224,400.00	266,496,065.78
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,200,000.00	19,200,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	33,935,889.75	106,430,300.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,092,508,343.00</b>	<b>1,096,100,930.22</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	556,869,400.00	552,079,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	556,869,400.00	552,079,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	535,638,943.00	544,021,330.22
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	169,081,504.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	149,440,000.00	104,164,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	122,306,643.00	270,775,526.22
131106	Төсвийн урамшуулал	263,892,300.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,389,292,518.94</b>	<b>1,386,291,543.16</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,389,292,518.94</b>	<b>1,386,291,543.16</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,348,440,930.73	1,329,159,833.11
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	708,715,901.00	747,224,814.09
210101	Үндсэн цалин	503,908,130.00	575,984,851.09
210102	Нэмэгдэл	00.00	36,065,771.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	46,540,000.00	48,336,000.00
210104	Урамшуулал	120,110,485.00	85,687,327.00
210105	Гэрээт ажлын хөлс	38,157,286.00	1,150,865.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	71,508,157.87	88,794,101.96
210201	Тэтгэврийн даатгал	42,259,588.62	63,722,697.25
210202	Тэтгэмжийн даатгал	8,538,313.22	4,726,584.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,494,253.00	6,357,755.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,137,588.03	1,271,553.71
210205	Эрүүл мэндийн даатгал	13,078,415.00	12,715,512.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	36,751,307.00	41,962,300.00
210301	Гэрэл, цахилгаан	14,750,259.00	20,160,104.00
210302	Түлш, халаалт	19,712,124.00	19,198,003.79
210303	Цэвэр, бохир ус	2,288,924.00	2,604,192.21
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	142,657,986.98	107,917,055.53
210401	Бичиг хэрэг	11,164,666.44	9,708,068.00
210402	Тээвэр, шатахуун	15,762,000.00	32,164,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,436,330.62	4,337,797.90
210404	Ном, хэвлэл	16,538,577.98	11,475,449.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,668,000.00	3,224,050.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	92,088,411.94	47,006,790.13
<b>2105</b>	<b>Нормативд зардал</b>	3,035,000.00	1,281,000.00

Монголын үндэсний музейн 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,035,000.00	1,281,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>58,858,732.00</b>	<b>113,744,239.58</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,876,632.00	5,872,000.00
210602	Тавилга	400,000.00	00.00
210604	Урсгал засвар	56,582,100.00	107,872,239.58
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>18,693,100.00</b>	<b>33,678,600.00</b>
210702	Дотоод албан томилолт	18,693,100.00	33,678,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>78,708,193.50</b>	<b>83,548,824.46</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	63,176,300.00	68,473,504.46
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,019,600.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	82,780.04	397,980.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	383,400.00	681,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	49,500.00	105,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,977,263.46	3,350,000.00
210807	Газрын төлбөр	295,680.00	295,680.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,723,670.00	8,245,460.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>229,512,552.38</b>	<b>111,008,897.49</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,859,110.00	5,269,444.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,837,700.00	4,758,240.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	189,815,742.38	100,981,213.49
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>40,851,588.21</b>	<b>57,131,710.05</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>10,530,000.00</b>	<b>00.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,530,000.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>30,321,588.21</b>	<b>57,131,710.05</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,321,588.21	57,131,710.05
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-21,423,886.19</b>	<b>101,935,752.84</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-21,423,886.19</b>	<b>101,935,752.84</b>

#### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,353,523,666.00</b>	<b>1,381,796,996.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>258,695,481.00</b>	<b>285,696,065.78</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	258,695,481.00	285,696,065.78
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	258,695,481.00	285,696,065.78
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	227,518,400.00	266,496,065.78
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	31,177,081.00	19,200,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,094,828,185.00</b>	<b>1,096,100,930.22</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	555,758,800.00	552,079,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	555,758,800.00	552,079,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	535,638,943.00	544,021,330.22
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	169,081,504.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	149,440,000.00	104,164,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	122,306,643.00	270,775,526.22
131106	Төсвийн урамшуулал	263,892,300.00	00.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	3,430,442.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,430,442.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,166,097,775.04</b>	<b>1,313,001,111.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,166,097,775.04</b>	<b>1,313,001,111.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,125,246,186.83</b>	<b>1,255,869,400.95</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	712,146,343.00	748,248,096.92
210101	Үндсэн цалин	507,338,572.00	577,008,133.92
210102	Нэмэгдэл	00.00	36,065,771.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	46,540,000.00	48,336,000.00
210104	Урамшуулал	120,110,485.00	85,687,327.00
210105	Гэрээт ажлын хөлс	38,157,286.00	1,150,865.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	71,436,800.43	88,794,101.96
210201	Тэтгэврийн даатгал	50,402,586.96	59,757,238.66
210202	Тэтгэмжийн даатгал	3,936,927.00	5,518,435.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,342,901.00	7,349,507.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,068,580.47	1,469,904.30
210205	Эрүүл мэндийн даатгал	10,685,805.00	14,699,017.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	36,751,307.00	41,962,300.00
210301	Гэрэл, цахилгаан	14,750,259.00	20,160,104.00
210302	Түлш, халаалт	19,712,124.00	19,198,003.79
210303	Цэвэр, бохир ус	2,288,924.00	2,604,192.21
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	70,634,389.90	87,195,800.00
210401	Бичиг хэрэг	12,199,814.44	12,623,959.40
210402	Тээвэр, шатахуун	15,762,000.00	27,125,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,433,330.62	4,242,297.90

Монголын үндэсний музейн 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210404	Ном, хэвлэл	8,336,288.90	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,868,000.00	3,224,050.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	27,034,955.94	39,980,492.70
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>5,170,000.00</b>	<b>3,000,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,170,000.00	3,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>69,661,132.00</b>	<b>118,925,012.74</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,035,732.00	12,153,000.00
210602	Тавилга	400,000.00	709,366.46
210604	Урсгал засвар	57,225,400.00	106,062,646.28
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>18,693,100.00</b>	<b>33,678,600.00</b>
210702	Дотоод албан томилолт	18,693,100.00	33,678,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>106,012,323.50</b>	<b>124,903,145.33</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	90,855,100.00	96,782,285.33
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,019,600.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	82,780.04	397,980.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	383,400.00	681,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	49,500.00	105,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,977,263.46	3,350,000.00
210807	Газрын төлбөр	295,680.00	295,680.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,349,000.00	21,291,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>34,740,791.00</b>	<b>9,162,344.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,903,091.00	5,324,644.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,837,700.00	3,837,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>40,851,588.21</b>	<b>57,131,710.05</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>10,530,000.00</b>	<b>00.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,530,000.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>30,321,588.21</b>	<b>57,131,710.05</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,321,588.21	57,131,710.05
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>187,425,890.96</b>	<b>68,795,885.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>188,542,051.00</b>	<b>68,795,885.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>188,542,051.00</b>	<b>68,795,885.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>188,542,051.00</b>	<b>68,795,885.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	188,542,051.00	68,795,885.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-188,542,051.00</b>	<b>-68,795,885.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-5,560.04</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>5,560.04</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2017 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,206,524,764.40</b>	<b>2,538,711,089.17</b>	<b>1,922,482,602.50</b>	<b>5,667,718,456.07</b>
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,206,524,764.40</b>	<b>2,538,711,089.17</b>	<b>1,922,482,602.50</b>	<b>5,667,718,456.07</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,206,524,764.40</b>	<b>2,538,711,089.17</b>	<b>1,922,482,602.50</b>	<b>5,667,718,456.07</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	2,997,764,987.40	-	2,997,764,987.40
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	108,796,800.00	-	-	108,796,800.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	101,935,752.84	101,935,752.84
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,315,321,564.40</b>	<b>5,536,476,076.57</b>	<b>2,024,418,355.34</b>	<b>8,876,215,996.31</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>802,292,300.00</b>	<b>801,854,939.73</b>	<b>437,360.27</b>	<b>99.9</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>802,292,300.00</b>	<b>801,854,939.73</b>	<b>437,360.27</b>	<b>99.9</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>802,292,300.00</b>	<b>801,854,939.73</b>	<b>437,360.27</b>	<b>99.9</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>560,423,100.00</b>	<b>560,086,151.13</b>	<b>336,948.87</b>	<b>99.9</b>
Үндсэн цалин	415,311,800.00	473,743,015.13	-58,431,215.13	114.1
Нэмэгдэл	68,251,300.00	38,007,136.00	30,244,164.00	53.5
Унаа хоолны хөнгөлөлт	76,860,000.00	48,336,000.00	28,524,000.00	62.9
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>67,250,800.00</b>	<b>67,150,428.60</b>	<b>100,371.40</b>	<b>99.9</b>
Тэтгэврийн даатгал	45,673,500.00	45,128,123.66	545,376.34	98.8
Тэтгэмжийн даатгал	5,394,300.00	4,115,524.00	1,278,776.00	76.3
ҮОМШӨ-ний даатгал	4,315,500.00	5,595,868.00	-1,280,368.00	129.7
Ажилгүйдлийн даатгал	1,078,900.00	1,119,174.94	-40,274.94	103.7
Эрүүл мэндийн даатгал	10,788,600.00	11,191,738.00	403,138.00	103.7
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>41,962,300.00</b>	<b>41,962,300.00</b>		<b>100</b>
Гэрэл, цахилгаан	15,981,500.00	20,160,104.00	-4,178,604.00	126.1
Түлш, халаалт	22,988,000.00	19,198,003.79	3,789,996.21	83.5
Цэвэр, бохир ус	2,992,800.00	2,604,192.21	388,607.79	87
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>28,596,800.00</b>	<b>28,596,800.00</b>		<b>100</b>
Бичиг хэрэг	6,176,700.00	5,884,959.40	291,740.60	95.3
Тээвэр, шатахуун	3,320,100.00	2,525,000.00	795,100	76.1
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,600,000.00	4,242,297.90	357,702.10	92.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	11,000,000.00	12,720,492.70	-1720,492.7	115.6
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,500,000.00	3,224,050.00	275,950.00	92.1
Нормативд зардал	3,000,000.00	3,000,000.00		100
Эд хогшил, урсгал засварын зардал	14,290,000.00	14,290,000.00		100
Урсгал засвар	14,290,000.00	14,290,000.00		100
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,248,600.00</b>	<b>2,248,600.00</b>		<b>100</b>
Дотоод албан томилолт	2,248,600.00	2,248,600.00		100
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>78,473,300.00</b>	<b>78,473,260.00</b>	<b>40.00</b>	<b>100</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	62,573,400.00	62,573,400.00		100

Монголын үндэсний музейн 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00		100
Даатгалын үйлчилгээ	398,000.00	397,980.00	20.00	100
Тээврийн хэрэгслийн татвар	681,200.00	681,200.00		100
Тээврийн хэрэгслийн оношилгоо	105,000.00	105,000.00		100
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,350,000.00	3,350,000.00		100
Газрын төлбөр	295,700.00	295,680.00	20.00	100
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,070,000.00	9,070,000.00		100
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,047,400.00</b>	<b>6,047,400.00</b>		<b>100.00</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	2,209,700.00	2,209,700.00		100
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,837,700.00	3,837,700.00		100
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>802,292,300.00</b>	<b>801,854,939.73</b>	<b>437,360.27</b>	<b>99.9</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>552,079,600.00</b>	<b>527,879,173.95</b>	<b>24,200,426.05</b>	<b>95.6</b>
Улсын төсвөөс санхүүжих	552,079,600.00	527,879,173.95	24,200,426.05	95.6
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>250,212,700.00</b>	<b>273,975,765.78</b>	<b>-23,763,065.78</b>	<b>109.5</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	231,012,700.00	254,775,765.78	-23,763,065.78	110.3
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,200,000.00	19,200,000.00		100
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>61.00</b>	<b>61.00</b>		<b>100</b>
Удирдах ажилтан	1.00	1.00		100
Гүйцэтгэх ажилтан	41.00	41.00		100
Үйлчилгээний ажилтан	19.00	19.00		100
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>61.00</b>	<b>61.00</b>		<b>100</b>

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>522,810,346.22</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>522,810,346.22</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		522,810,346.22
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		188,161,945.79
210101	Үндсэн цалин		103,265,118.79
210104	Урамшуулал		84,896,827.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		21,643,673.36
210201	Тэтгэврийн даатгал		14,629,115.00
210202	Тэтгэмжийн даатгал		1,402,911.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		1,753,639.00
210204	Ажилгүйдлийн даатгал		350,729.36
210205	Эрүүл мэндийн даатгал		3,507,279.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		58,839,000.00
210401	Бичиг хэрэг		6,739,000.00
210402	Тээвэр, шатахуун		24,600,000.00
210404	Ном, хэвлэл		240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		27,260,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		156,644,892.74
210601	Багаж, техник, хэрэгсэл		32,561,000.00
210602	Тавилга		32,311,246.46
210604	Урсгал засвар		91,772,646.28
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		31,430,000.00
210702	Дотоод албан томилолт		31,430,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		62,975,890.33
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		50,754,890.33
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		12,221,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	0.00	3114944.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		3,114,944.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	522810346.22
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		522,810,346.22
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		168,970,520.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		83,064,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		270,775,526.22
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

**5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо: <b>2019.02.25</b>	Аудитын нэр: <b>Монголын үндэсний музейн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит.</b>	Аудитын код: <b>САГ-2019/10/СТА-ТШЗ</b>
Шалгагдсан байгууллагын нэр: <b>Монголын үндэсний музей</b>	мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Төсвийг зүй зохистой удирдаагүйгээс зохистой авлага үүсгэсэн байна.	1,023.0	Зөвлөмж	Захирал, нягтлан бодогч	Д.Сүхбаатар Ө.Отгон
2	УБЦТС ХК-д 2017 оны жилийн эцсийн тайлангаар илүү шилжүүлсэн боловч авлагаар бүртгээгүй байсны улмаас тайлант оны үр дүн буруу илэрхийлэгдсэн байна.	1,068.7	Зөвлөмж	Захирал, нягтлан бодогч	Д.Сүхбаатар Ө.Отгон
3	Өмнөх жилүүдэд шаардах хуудсаар зарлага болгоогүй, бараа материалын тайлангийн үлдэгдэлд бодит бус байсан машины сэлбэг хэрэгслийг тайлант онд акталсан байна	5,556.0	Зөвлөмж	Захирал, нягтлан бодогч	Д.Сүхбаатар Ө.Отгон
	<b>Дүн</b>	<b>7,647.7</b>			

